Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн хэмжээнд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй бөгөөд шинээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 126,729.9 мянган төгрөгөөр буюу 12,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Авлага	0	45.0	45.0
Бараа материал	98,563.4	107,852.5	9,289.1
Үндсэн хөрөнгө	936,680.5	1,054,076.3	117,395.8
Нийт хөрөнгө	1,035,243.9	1,161,973.8	126,729.9
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,035,243.9	1,161,973.8	126,729.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,035,243.9	1,161,973.8	126,729.9

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд 45.0 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 98,563.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 57,322.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ХХААГ-аас 5,000.0 мянган төгрөгийн 20 хурган хуц, нас дэвшил, төлийн орлогоор 1,000.0 мянган төгрөгийн мал амьтад, орон нутгийн хөгжлийн сангаас 2,550.0 мянган төгрөгийн ногоон тэжээл, 15,443.3 мянган төгрөгийн ахуйн үйлчилгээ, уурын зуух, соёлын төвийн барилгын засварын зураг төсөв, хэмжилтийн зураг, нийт 23,993.3 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 69,515.9 мянган

төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2,930.7 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, аж ахуйн материалыг актлаж устгаснаар бараа материалын эцсийн үлдэгдэл 107,432.5 мянган төгрөг болж, 9,289.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Өвөлжилтийн байдлыг хангах зорилгоор малын ногоон тэжээл 2,550.0 мянган төгрөгөөр, ХХААГ-аас 5,000.0 мянган төгрөгийн хуц авсан, ахуйн үйлчилгээ, уурын зуух, соёлын төвийн барилгын засварын зураг төсөв, хэмжилтийн зураг 15,443.3 мянган төгрөгөөр бэлгэсэн зэрэг нь бараа материалын өсөлтөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 1,357,961.3 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 27,521.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бэлтгэж, сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны А/186 дугаар захирамжаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 15,000.0 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, 14,500.0 мянган төгрөгийн өндөрлөг хаалганы засварын сайжруулалт, аймгийн Цагдаагийн газраас 4,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, ХХААГ-аас шинэ хөдөө төслийн хүрээнд 56,309.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 105,872.7 мянган төгрөгийн хадлан тэжээл бэлтгэх иж бүрдэл багц тоног төхөөрөмж, нийт 196,181.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр орлого авч, 13,298.6 мянган төгрөгийн хогны хашаа, мотоцикль, бусад тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл акталж устгаснаар, үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,568,336.2 мянган төгрөг болсон байна.

Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардал 102,562.7 мянган төгрөгөөр бүртгэж, хөрөнгийн үлдэгдэл өртөг 117,395.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,161,973.8 мянган төгрөг болж 126,729.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 367,969.8 мянган төгрөг, зарлагыг 367,969.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГ-ын хүргүүлсэн төсвийн төслөөс 23,924.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, сумын ИТХ-ын 2021 оны 32 дугаар тогтоолоор 391,893.8 мянган төгрөгийн төсөв 2022 оны санхүүгийн жилд зарцуулж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант хугацаанд сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 05 тоот тогтоолоор урсгал зардлыг 443,769.9 мянган төгрөгөөр, зардал санхүүжүүлэх эх үүсвэрийг сумын шилжих үлдэгдлээс 127,427.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 352,999.9 мянган төгрөг, нийт 443,769.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгож баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 391,893.8 мянган төгрөгийг 51,876.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх 441,219.9 мянган төгрөг, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэх 2,550.0 мянган төгрөг, нийт 443,769.9 мянган төгрөгийн зардлыг, орон нутгийн төсвөөс 352,999.9 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 90,770.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсны дагуу

гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 15,915.5 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 427,854.4 мянган төгрөг буюу 96,4 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, цалингийн зардлаас 6,460.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 3,151.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 692.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлаас 3,195.4 мянган төгрөг нийт 15,915.5 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	311,537.6	302,614.8	8,922.8	97.1%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	39,896.1	35,201.6	4,694.5	76.5%
3	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал	50,745.0	48,844.9	1,900.1	96.3%
4	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	17,541.2	17,539.2	2.0	100%
5	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 81701- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	1,500.0	1,500.0	0	100%
6	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	15,000.0	14,638.9	361.1	97.6%
7	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 82801- Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100%
8	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 82212- Хур хог хаягдал, орчны бохирдол	2,550.0	2,515.0	35.0	98.6%
	Дүн	443,769.9	427,854.4	15,915.5	96.4%

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээр хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээний зардалд 20,170.0 мянган төгрөг, урсгал засвар тоног төхөөрөмжийн зардалд 19,000.0 мянган төгрөг, нийт 39,170.0 мянган төгрөгийг тодотголоор батлуулж, өрөө тасалгааны урсгал засварт 12,000.0 мянган төгрөг, төрийн албан хаагчдын эрт илрүүлэг, үзлэг шинжилгээний хөнгөлөлтөд 2,047.0 мянган төгрөг, машин техникийн урсгал засварт 3,800.0 мянган төгрөг, албан хаагчдын компьютер тоног төхөөрөмжийг шинэчлэхэд 16,374.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГ нь 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДТГ-аас малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шатахууны зардалд 1,555.7 мянган төгрөг, биотехникийн арга хэмжээнд 1,500.0 мянган төгрөг, сонгуулийн үр дүнд ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 5,153.2 мянган төгрөг, газрын дуудлага худалдаанаас 9,500.0 мянган төгрөг, статистикийн хэлтсээс ээлжит тооллогын болон тандалт судалгааны зардалд 3,302.1 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажил зуучлалын зардалд 66.0 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 308.0 мянган төгрөг, усны үнэнд 659.4 мянган төгрөг, өвсний үнэнд 7,471.0 мянган төгрөг, өөрийн орлого 687.0 мянган төгрөг, хөдөө аж ахуйн зориулалтаар газар түрээслүүлсний орлого 2,500.0 мянган төгрөг, өмнөх оны татан төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийн орлого 12,056.9 мянган төгрөг, нийт 44,759.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шатахууны зардалд 1,555.7 мянган төгрөг, хэвлэмэл хуудас хэвлүүлэхэд 490.0 мянган төгрөг, шатахууны зардалд 2,356.0 мянган төгрөг, сонгуулийн үр дүнд ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 5,153.2 мянган төгрөг, тооллого судалгааны арга хэмжээнд 3,302.1 мянган төгрөг, хүндэтгэл үзүүлэх болон барилдаан зохион байгуулах арга хэмжээнд 2,850.0 мянган төгрөг, барилгын урсгал засварт 3,300.0 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн засварын зардалд 6,155.0 мянган төгрөг, нийт 25,161.9 мянган төгрөгийг зарцуулж, тайлант онд зарцуулаагүй 19,912.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлж тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн найман арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хэрэгжсэн, биелэлт 96.4%	441,219.9	425,339.4
2	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022.01.01-2022.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	Хэрэгжсэн, биелэлт 98.6%	2,550.0	2,515.0
Нийт төсвийн дүн					443,769.9	427,854.4

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газрын 70106 хөтөлбөр 96,4% буюу 15,880.5 мянган төгрөгөөр дутуу хэрэгжсэн нь 80101 арга хэмжээний үндсэн үйл ажиллагааны зардал 97,1 хувьтай, 80103 арга хэмжээний гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал 76,5 хувьтай, 80106 арга хэмжээний баг хорооны ажил, үйлчилгээний зардал 96,3 хувьтай гүйцэтгэл гарснаас хамаарсан байна. Мөн 71411 хөтөлбөр нь 98,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/02 тоот албан бичгээр Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт зарлага 443,769.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,656.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,992.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт хавсаргаж ирүүлсэн. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, цалингийн зардлаас 6,460.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 3,151.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 692.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлаас 3,195.4 мянган төгрөг нийт 15,915.5 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газрын албан хаагчдад 2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу гар утасны зардал, ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал, хэвлэлийн төлбөр олгоогүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 1 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 19 орлогын, 9 зарлагын мөнгөн гүйлгээнээс зарлагын 1 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бөгөөд өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 62 шийдвэрийг хугацаанд нь байршуулснаар шилэн дансны хэрэгжилт 92,3 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 4 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 2 зөвлөмж нь үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

Шилэн дансны хэрэгжилт, шилжих үлдэгдлийн зарцуулалтын талаар өгсөн зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн гэж үзэн энэхүү тайланд тусгаж, зөвлөмж хүргүүллээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт, 2 албан шаардлагын биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 13-ний өдрийн 03/34 тоотой Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,422.6	1	1,422.6	100%
Албан шаардлага	2	29,483.3	2	29,483.3	100%
Зөвлөмж	0	0	0	0	0%
Нийт дүн	3	30,905.9	3	30,905.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд тайлант оны элэгдлийн зардлыг бодуулаагүйгээс 102,562.7 мянган төгрөгийг алдаатай тайлагнасныг аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залрууллаа.

Аудитаар нийт 29,936.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,204.4 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,812.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 23,920.0 мянган төгрөгийн 2 зөрчилд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Нэмэлт санхүүжилтийн дансанд газрын түрээсийн орлого 2,500.0 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлогын үлдэгдэл 45.0 мянган төгрөг, усны төлбөрийн 659.4 мянган төгрөг, нийт 3,204.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлээгүй зөрчил байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх” зарчимтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “ангилал”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

Бараа үйлчилгээний зардлаас 2,812.0 мянган төгрөгийг дотоод албан томилолтын зардалд гүйлгэн зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” бол албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Мал амьтадын дансанд бүртгэлтэй 23,920.0 мянган төгрөгийн 280 толгой малын нэг бүрийн үнэ нь 10.0 мянган төгрөгөөс 100.0 мянган төгрөгийн бодит биш үнэлгээтэй, төсвийн хөрөнгийг хэт үнэгүйдүүлж байгаа зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн” 5.1.4-д “үнэн зөв байх” зарчим болон Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 411 тоот тушаалаар баталсан “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ыг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.Өгсөн зөвлөмж:

Мал амьтадад бодитой үнэлгээ тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.”, 20 дугаар зүйлийн 20.2.2-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасантай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.1.2Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуул- сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							залруулсан		залруулаагүй			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Тайлант оны элэгдлийн зардлыг бодуулаагүйгээс 102.562.7 мянган төгрөгийг алдаатай тайлагнасан байна.	1	102,562.7			1	102,562.7	1	102,562.7				
Дүн	1	102,562.7	0	0.0	1	102,562.7	1	102,562.7	0	0.0	0	0.0

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	тоо	дүн										
Нэмэлт санхүүжилтийн дансанд газрын түрээсийн орлого 2.500.0 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлогын үлдэгдэл 45.0 мянган төгрөг, усны төлбөрийн 659.4 мянган төгрөг, нийт 3.204.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлээгүй зөрчил байна	1	3,204.4	1	3,204.4								
Бараа үйлчилгээний зардлаас 2,812.0 мянган төгрөгийг дотоод албан томилолтын зардалд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан зөрчил байна.	1	2,812.0			1	2,812.0						
Мал амьтадын дансанд бүртгэлтэй 23.920.0 мянган төгрөгийн 280 толгой малын нэг бүрийн үнэ нь 10.0 мянган төгрөгөөс 100.0 мянган төгрөгийн бодит биш үнэлгээтэй, төсвийн хөрөнгийг хэт үнэгүйдүүлж байгаа зөрчил байна.	1	23,920.0					1	23,920.0				
Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй зөрчил байна	1	0.0					1					
Дүн	4	29,936.4	1	3,204.4	1	2,812.0	2	23,920.0	0	0.0	0	0.0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
Нийт дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0